

УУЛ УУРХАЙН ТЕХНИК АШИГЛАЛТЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох ажил үйлчилгээнд ашиглагдаж байгаа машин механизм, технологийн зориулалт бүхий хамгаалалтын байгууламжид тавигдах техникийн аюулгүй ажиллагааны шаардлага, горимыг мөрдөггүйгээс малталтын үед нуралт үүсэх, ажлын орчинд хортой хий хуримтлагдах аюул эрсдэлээс хүний амь, эрүүл мэнд хохирох тохиолдолд буурахгүй байна.

Иймд болзошгүй аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх, осолд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг таслан зогсоох талаар дараах ЗӨВЛӨМЖ-ийг зайлшгүй хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Уурхайн ажилтнуудыг газрын дээр гаргахад зориулсан хоорондоо хамааралгүй агаарын урсгалын эсрэг чиглэлд хоёроос доошгүй гарцыг олборлолт эхлэхээс өмнө аюулгүй байдлын дүрэмд заасан шаардлагад нийцүүлэн гаргасан байх, мөн аюул, ослын үед гарах зориулалтын гарцыг бий болгох, тэмдэг тэмдэглэгээ бүхий аюултай бүсийн хязгаарлалт тогтоох “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 10, 31, 32, 33, 34, “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 17 дахь заалт;



2. Уулын бүх малталтыг батлагдсан зураг төсөл, паспортын дагуу бэхэлгээний паспортын дагуу дүрэмд заасан шаардлага, технологийн дагуу мэргэжлийн хүмүүсийн удирдлагын хяналтын дор гүйцэтгэх, уурхайн аманд нуралт гулсалтаас хамгаалсан бэхэлгээг мод, бетон, шуудайлж савласан шороогоор хийж чигжих “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 1.3, 39, 40, 41, “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 18 дахь заалт;



3. Агааржуулалтын системийг мэргэжлийн ажилтны заавар, зөвлөмж, хяналтын дор төлөвлөн ашиглах, тасралтгүй найдвартай ажиллагааг хангахуйц техник зохион байгуулалтын арга хэмжээг авах, агааржуулаагүй малталанд хүн оруулахыг хориглох “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 101, 108, “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг 31 дэх заалт;



4. Уурхайд зориулалтын бус /гар хийцийн/ үйлдвэрлэлийн технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглахгүй байх, малталтын бэхэлгээний хана таазанд гарсан ан цавыг байнга, бусад бэхэлгээний байдлыг сард 2-оос доошгүй удаа, агааржуулалтыг өдөр бүр, суурилагдсан тоног төхөөрөмж, байгууламж нэг бүрийг техникийн паспортод заасан хугацаанд үзлэг шалгалт хийх, тоноглолын засвар үйлчилгээг аюул осолгүй гүйцэтгэх зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 25, 26, “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 34, 210, 211, 212, 312 дахь заалт;



5. Уурхайн олборлолт явуулсан газар болон цаашид ашиглахад аюул, осол болон хүндрэл бэрхшээл учруулж болзошгүй далд малталтыг зогсоож аюулгүй болгох /хаалт хамгаалалт хийх/ “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 19, 20, 21, 23, “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”- ийн 27, 28 дахь заалт;



6. Шат, хүн явах зам, тээврийн зам болон бүх ажлын байрууд нь газардуулах ёстой бүх объектуудыг холбосон газардуулгын нэгдсэн сүлжээ байгуулах, үл хамаарах тэжээл бүхий үндсэн болон ослын гэрэлтүүлэгтэй байлгах, уурхайд орж буй хүн бүр бүтэн ажиллагаатай малгайн гэрэлтэй байна. “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 455, 462, 480 дахь заалт;



Иймд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, Уул уурхайн сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 229/А/232 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”, АМГ-ын даргын 2011 оны 153-р тушаалаар баталсан “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”- ийг мөрдөж ажилласнаар Та бид бүгдээрээ болзошгүй аюул, эрсдэлээс өөрсдийгөө хамгаалж, эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэх юм.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ТУСГАЙ ХЯНАЛТЫН ХЭЛТЭС